

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт,  
оруулж батлах тухай

Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.6 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15 дахь заалт, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалт, 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 25/02, 25/03, 25/04 тогтоолуудыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн албан ёсны хаягийг Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17 дугаартай барилгын 9 дүгээр давхар болгон өөрчилсүгэй.
2. “Ард Кредит ББСБ” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд Факторингийн үйлчилгээг нэмсүгэй.
3. Үйл ажиллагааны чиглэл нэмэх, албан ёсны хаягийг өөрчилсөнтэй холбогдуулан Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
  - 3.1. Компанийн дүрмийн 1.7 дахь заалтыг “Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17 дугаартай барилгын 9 дүгээр давхар” болгон өөрчлөх;
  - 3.2. Компанийн дүрмийн 2.3.7 дахь заалтад “Факторингийн үйлчилгээ” гэж нэмэлт оруулах.
4. Энэхүү шийдвэрийн 3 дахь заалтад заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
5. Энэхүү шийдвэрийн 1 дэх заалтад заасны дагуу Компанийн албан ёсны хаяг өөрчлөх, 2 дахь заалтад заасны дагуу үйл ажиллагааны чиглэл нэмэхтэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох зөвшөөрөл хүсэх, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгосугай.
6. Хавсралтаар батлагдсан Компанийн дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, бүртгүүлдтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
7. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Ч.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА



Г.СҮХБААТАР